

Хуримтлагдсан цэнэг үүсэж байвал анхаарах шаардлагатай !!

2025 оны 3 сар



1-р зураг

Хуримтлагдсан
цэнэг цахих

2-р зураг

Газардуулгын
утас бүхий шугам
хоолой



Кэйс 1 Оператор эмийн нунтгийг механик чичиргээт шигшүүр рүү гар аргаар нэмж шигшиж байв. Шигшсэн нунтаг нь шигшүүрийн доор байрлуулсан жижиг нейлон дугуйтай зэвэрдэггүй ган сав руу орж байсан. Шигшүүр болон савны хооронд тоосны тэсрэлт болсон. Оператор гал гарахаас өмнө хэдэн сарын турш ган савнаас багахан цахилгаан цахиж байгааг анзаарсан боловч ингэж цахилгаан цахих нь галын эх үүсвэр болно гэдгийг мэдээгүй.

Кэйс 2 Оператор гялгар уутнаас реактор руу нунтаг материал нэмж байсан. Гэнэт гал авалцаж операторыг нөмөрсөн. Оператор гэмтэл аваагүй. Энэ осол болохоос өмнө, анхаарал татсан үйл явдал хэд хэдэн удаа тохиолдсон. Нунтаг материал гялгар уутанд цахилгаанжин наалдаж, уутыг суллахад хүндрэл учирч байсан. Гулгар уут операторын биед, мөн реакторт наалдаж байсан.

Та мэдэх үү?

- Хуримтлагдсан цэнэг нь шатамхай, ноцомхой материалд галын эх үүсвэр болдог. (2008.12, 2021.02 сарын мэдээллүүдийг харна уу)
- 2 гадаргуу шүргэлцээд салах үед статик цахилгаан цэнэг хуримтлагдах боломжтой. Даралтаар материал зөөвөрлөх, шигших, тээрэмдэх, холих, юүлэх үед энэ үзэгдэл болж мэднэ.
- Хатуу, шингэний хооронд буюу шингэнийг зөөвөрлөх, холих, шүүх үед эсвэл 2 хатуу гадаргуу хооронд буюу сав руу материал юүлэх эсвэл суллах, шугам хоолой дундуур урсгах үед цэнэг хуримтлагдах боломжтой.
- Эл үзэгдэл мөн хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөс ч үүснэ. Жишээ нь: туузан дамжуургын тууз ролик дээгүүр явж өнгөрөх
- Хуримтлагдсан цэнэг үүсэж байгаа шинж тэмдэг:
 - Тасхийх чимээ гарах
 - Нүдэнд үзэгдэхүйц нум үүсэх, цахилгалт үүсэх
 - Гар, сарвуунд хатгах мэдрэмж төрөх
- Газардуулга болон газардуулгын холболтын цэг нь статик цэнэг хуримтлагдахаас сэргийлдэг бөгөөд үр дүнтэй байхын тулд байнга хянаж, шалгаж байх ёстой (2-р зураг).
- Суурин болон зөөврийн хэмжүүр ашиглан статик цэнэг хуримтлагдаж байгааг илрүүлж болно.

Та яах ёстой вэ?

- Дээрх хуримтлагдсан цэнэгийн шинж тэмдгийг анхаарч үзэх хэрэгтэй. Хэрэв өөрчлөлтийг харж, сонсож, мэдэрсэн бол ахлах ажилтандаа хэлж, шалгуул.
- Хуримтлагдсан цэнэг үүсэж байгаа шинж тэмдгийг ахлах ажилтандаа мэдээллэ. Ахлах ажилтан ажлын захиалга үүсгэн, хүн явуулан шалгуулж, засуулна.
- Газардуулгын кабель гэмтсэн, суларсан бол ахлах ажилтандаа мэдээллэ.
- ААДШ хийх үедээ хуримтлагдсан цэнэгийг галын эх үүсвэрээр авч үзэх
- Тоосны аюулын дүн шинжилгээ хийх үедээ цэнэг хуримтлагдах эрсдэлийг тооц. Хатуу төлөвтэй материал зөөвөрлөх үед хуримтлагдсан цэнэг үүсэх нь түгээмэл тохиолдоно.

Анхаарвал зохино !!